



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2017 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

**Төвийн ажилтнуудын ёс зүйн
дүрэм батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 288 дугаар тогтоолын хавсралтын 2.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- 1.Төвийн багш, ажилтнуудын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор ёс зүйн дүрэм батлан мөрдүүлсүгэй.
- 2.Төвийн ажилтнуудын ёс зүйн дүрмийг хавсралтаар баталсугай.
- 3.Төвийн ажилтнуудын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Даргын дэргэдэх зөвлөл /Н.Нэргүй/-д үүрэг болгосугай.



ДАРГА /Н.НЭРГҮЙ/ ЦЭРЭНДУЛАМ

318060201



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН АЖИЛТНУУДЫН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Тусгай төвийн ажилтан, албан хаагчид хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх, халамж хамгааллын үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд чанартай хүргэх, үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлж хэвшүүлэх, байгууллагын болон ажилтнуудын нэр төрийг хамгаалахад энэхүү дүрэмийн зорилго оршино.

2. Энэхүү дүрэм нь орон нутгийн анхан шатны байгууллагаас халамж хамгааллын зорилтот бүлэгт хүргэж байгаа төвийн ажилчдаас чанартай, соёлтой, ил тод түргэн шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ ажилтныг Хөдөлмөрийн дотоод журам, бусад хууль эрх зүйн баримт бичгүүдэд заасан нийтлэг үүргээ чанд биелүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлсэн байх зарчим, ёс зүйн хэмжээг тогтоож өгсөн эрх зүйн баримт бичиг болно.

Хоёр. Ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээ

2.1 Ажилтнууд эрх үүргээ биелүүлж, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх хүрээнд:

2.1.1 Иргэдтэй ажиллахдаа тэднийг хүндэтгэн илэн далангүй, илгэмсэг дотно байж, ар гэрийнхнийг нь орлож, тэдний сайн найз хамтрагч байж, тэдэнд сэтгэл санааны дэм өгч, эрх үүргийнх нь талаар харилцан ярилцаж, юу хийж болох, юу хийж болохгүйг, бэрхшээлтэй асуудал тулгарвал юу хийх ёстойг хэлж өгөх зэргээр нөхөрсөг дулаан харилцааг бүрдүүлж ажиллах.

2.1.2 Иргэдэд тавих шаардлага нь тэдний нийгэмшихүйн хөгжлийн болон хувь хүний онцлогт тохирсон байх төдийгүй тэдний гадаад өнгө үзэмж, биеэ авч яваа байдлаар нь ялгаварлан гадуурхахгүй, эрх тэгш харьцах.

2.1.3 Биеэ авч явах байдал, ажил үйлчилгээ үйл ажиллагаандаа хариуцлага хүлээж, үүрэгт ажилдаа идэвхигүй хандах, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зүй бус үйлдлүүдийг гаргахгүй байх.

2.1.4 Иргэдийн хувийн нууцыг чандлан хадгалах бөгөөд тэдний хувийн асуудлыг хоорондоо илээр хэлэлцэн ярилцах, нэр төр, үзэл бодлыг үгээр басамжлан доромжлохгүй байх.

2.2 Хамт олон бүтээлч, нөхөрсөг, шударга өрсөлдөөнийг хангасан орчин төлөвшүүлэхийг эрмэлзэж хамтран ажиллах хүрээнд:

2.2.1 Хамтран ажиллагчдынхаа нас, хүйс, хувийн онцлог, албан тушаал, мэдлэг туршлагаар нь ялгаварлахгүйгээр хүндэтгэлтэй харилцах.

2.2.2 Өөрийн болон байгууллагын нэр хүнд амжилтын төлөө хамт олон, хувь хүний нэр төр, эрүүл мэнд, сэтгэл санаа, хувийн өмчид хохирол учруулахгүй байх.

2.2.3 Ажлын туршлагаа бусадтай хуваалцан, хувийн болон байгууллагын эрх ашгийг зөв хослуулж, хамт олны эв нэгдлийг дээдлэх.

2.2.4 Байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохдоо хариуцлагатай хандаж, хамтын хариуцлага хүлээн, хөдөлмөрийн сахилгыг чанд сахин ажиллах.

2.2.5 Хууль тогтоомжийн хүрээнд хөдөлмөрлөх нөхцөлөө сайжруулахад санаа тавьж, мэдлэг чадвараа хөгжлийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй дээшлүүлж, хоцрогдлоос сэргийлэх

2.2.6 Хамт олны дунд хов жив гаргах, зөв уур амьсгалыг эвдэж, бие биендээ үл итгэх байдлыг бий болгохоос сэргийлэх

2.2.7 Удирдлага, хамт олон, иргэд болон олон нийтээс учруулж болзошгүй зүй бус эрсдлээс хамт олны болон өөрийн нэр төрийг хамгаалах

Гурав. Ажилтнуудын ёс зүйн дүрмийн хэрэгжилт

3.1 "Ёс зүйн дүрэм"-ийн заалтуудыг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн хуулийн хүрээнд хариуцлага хүлээлгэх ба энэ талаарх заалтуудыг байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд тусгана.